

МУИС-ИЙН БАГШИЙН АЖЛЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ (АТТЕСТАТЧИЛЛЫН) ЖУРАМ¹

1. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү журмаар МУИС-ийн профессор, багшийн (цаашид багш гэнэ) зайлшгүй гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг үнэлэх, дүгнэх, үр дүнг тооцох асуудлыг зохицуулах ба аттестатчиллын зорилго нь багш тухайн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлагыг хэрхэн хангаж байгааг тогтооход оршино.
- 1.2. Багш МУИС-д ажилласан эхний 15 жилд 3 жил тутамд, 15-аас дээш жилд 5 жил тутамд энэ журмын дагуу ажлаа үнэлүүлэх ба ажлын нэгдсэн үнэлгээ нь тухайн багшийн албан тушаалын зэрэглэл, цалингийн шатлалыг ахиулах/бууруулах, хөдөлмөрийн гэрээг сунгах/цуцлах, урамшуулах, шагналд дэвшүүлэх зэрэгт голлох үндэслэл болно.
- 1.3. Нэгдсэн үнэлгээнд МУИС-д үндсэн орон тоогоор болон 25, 50 хувиар ажилладаг гэрээт багш хамрагдана. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 25 болон түүнээс дээш жил ажилласан МУИС-ийн профессорыг өөрийн үнэлгээний тайлан бичүүлж, оюутны үнэлгээ авах замаар аттестатчилна. Дадлагажигч багш ажлаа үнэлүүлэн багшаар томилогдсоныг аттестатчилалд орсонд тооцно.
- 1.4. Бүрэлдэхүүн сургууль бүрт тухайн хичээлийн жилд аттестатчиллын комиссыг захирлын тушаалаар байгуулж, захирал өөрөө ахална. Багшийн ажлын үнэлгээг үнэн зөв, шударга, бодитой, ил тод явуулах үүргийг тухайн ажлыг гардан гүйцэтгэх захирал хариуцна.
- 1.5. Аттестатчиллын дүнгээр багштай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд комиссын өгсөн үнэлгээ, дүгнэлт, тодорхойлолтыг мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гэж үзнэ.

2. Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний агуулга

- 2.1. Багшийн ажлыг дараах 3 чиглэлээр үнэлнэ. Үүнд:
 - а) сургалт, заах арга зүй;
 - б) эрдэм шинжилгээний ажил;
 - в) мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ.
- 2.2. Багшийн нийт гүйцэтгэвэл зохих үүрэгт ажлыг 100 оноогоор дүгнэх бөгөөд багшийн албан тушаалын зэрэглэлээс хамаарч үндсэн 3 чиглэлээр онооны хуваарилалт нь дараах хүснэгтэд заасан хэмжээтэй байна.

*Багшийн албан тушаалын зэрэглэл,
гүйцэтгэх үндсэн ажилд харгалзах оноо*

Багшийн албан тушаалын зэрэглэл	Сургалт, заах арга зүй	Эрдэм шинжилгээ	Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ
Профессор	30	40	30
Дэд профессор	35	35	30
Ахлах багш	40	30	30
Багш	45	25	30

- 2.3. Эдгээр чиглэлийг дотор нь үйл ажиллагааны тодорхой хүрээгээр дэд хэсгүүдэд хуваах бөгөөд тэдгээрийн үнэлгээний оноонд эзлэх хувь нь албан тушаалын зэрэглэлээс хамаарахгүй тогтмол байна. (Жишээ нь: дэд профессорын ажлын үнэлгээнд Сургалтын технологи болон хэрэглэгдэхүүнийг шинэчлэх гэсэн дэд хэсэгт хамгийн ихдээ 10.5 оноо ноогдох ба түүний дотор буй 3.1.6.-д заасан ажилд тухайлан хэдэн оноо өгөх нь мэргэжлийн удирдлага болон комиссын мэдлийн асуудал байна). Харин дэд хэсэгт дурдсан ажлуудыг бүгдийг нь хийсэн байхыг багшаас шаардаж болохгүй.

¹ Захирлын 1999 оны 586 тоот тушаалаар баталж, 2003 оны 633, 2009.12.17-ны өдрийн 802, 2011.06.30-ны өдрийн 366 тоот тушаалаар өөрчлөлт оруулсан журмын шинэчилсэн найруулга

3. Багшийн ажлыг үнэлэх чиглэл

3.1. Сургалт, заах арга зүй

Сургалтын ажил (30%)

- 3.1.1. танхимд хичээл заах;
- 3.1.2. хээрийн, үйлдвэрлэлийн болон сурган хүмүүжүүлэх дадлага удирдах;
- 3.1.3. сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, цахим сургалтын хэрэглэгдэхүүн шинээр боловсруулах, шинэчлэх;
- 3.1.4. шинэ хэлбэрийн ажил, туршилт санаачлан сургалтын арга зүйг өөрчлөн сайжруулах;
- 3.1.5. оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн (интернет, мэдээллийн технологи, дууриах (симуляци), асуудал шийдвэрлүүлэх, тоглоомын арга, тодорхой тохиолдлын жишээлсэн судалгаа (кейс) г.м) сургалтын шинэлэг арга барилаар хичээл заах.

Сургалтын технологи болон хэрэглэгдэхүүнийг шинэчлэх (30%)

- 3.1.6. сургалтын хэрэглэгдэхүүнийг нээлттэй эхийн боловсролын (OCW) агуулга, загвараар боловсруулж, МУИС-ийн нээлттэй сургалтын цахим хуудсанд байршуулах (тухайн хичээлийн лекц, семинар /дадлага/-ыг бүрэн хамруулах);
- 3.1.7. оюутан бие даан суралцахад зориулсан нэмэлт хэрэглэгдэхүүн боловсруулах;
- 3.1.8. лабораторийн ажил, хичээлийн үзүүлэн шинэчлэх, шинээр боловсруулах, программ хангамж бичиж, зүгшрүүлэх;
- 3.1.9. хичээл, сургалтанд дэвшилтэт арга барил, техник хэрэгсэл ашиглах;
- 3.1.10. сургалт, судалгааны мэдээлэл, сургалтын багц хэрэглэгдэхүүнийг электрон хэлбэрт шилжүүлэн сургуулийн цахим хуудсанд байрлуулж, оюутанд нээлттэй хэрэглүүлэх боломж олгох зэргээр сургууль-багш-оюутан хоорондын цахим харилцааны боломжийг өргөтгөх.

Оюутантай ажилласан байдал (30%)

- 3.1.11. оюутны бие даан суралцах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- 3.1.12. хичээлийн бус цагаар тодорхой хуваариар оюутанд зөвлөгөө өгөх;
- 3.1.13. курс, дугуйлан удирдан хичээллүүлэх;
- 3.1.14. оюутны мэдлэг, чадварыг үнэлсэн арга, улирлын ба дундаж дүн, амжилт, чанар;
- 3.1.15. хичээлийн агуулга, зорилгод тохируулан оюутныг мэдлэг, чадварын үнэлгээнд хэрэглэсэн сорилго, бусад аргыг баяжуулах;
- 3.1.16. реферат, гэрийн уншлага, бие даалт шалгах зэрэг хэлбэрээр танхимын сургалтаас бусад цагаар суралцагчдын мэдлэг чадварыг үнэлэх, явцын болон улирлын шалгалт авах.

Даалгаварт болон бусад ажил (10%)

- 3.1.17. бакалаврын оюутны судалгааны ажил болон магистр, докторын дипломын ажилд шүүмж өгөх, болзлын шалгалт авах комисст ажиллах;
- 3.1.18. гарын авлага бичих, лабораторийн ажил тавих, шинэчлэх зэрэг сургалттай холбоотой аливаа даалгаварт ажил гүйцэтгэх;
- 3.1.19. сургалтын арга технологийг боловсронгуй болгох, шинэчлэхтэй холбоотой тусгайлсан даалгаварт гүйцэтгэх;
- 3.1.20. элсэлт, төгсөлтийн ажил зохион байгуулахад оролцох;
- 3.1.21. заах арга зүйн мэдлэг, боловсролоо дээшлүүлэх.

3.2. Эрдэм шинжилгээний ажил

Хамтын бүтээлд оруулсан хувь нэмрийг зохиогч нараар ялган тодотгосон байх шаардлагатай. Ийм бололцоогүй нөхцөлд “МУИС-ийн багшийн орон тоо, ажлын үнэлгээний журам”-ын зохих заалтыг жишиг болгоно. Өмнөх аттестатчиллаар тайлагнасан судалгаа,

шинжилгээний бүтээлийг үнэлгээнд тооцохгүй. Харин их хэмжээгээр шүүн засварласан бүтээлийг тэр тухай тайлбартайгаар оруулж болно.

Эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл (40%)

- 3.2.1. тухайн судалгааны салбарын индекстэй сэтгүүл, индексгүй боловч мэргэжлийн түвшинд /peer-review/ хянагддаг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- 3.2.2. олон улсын хуралд уригдсан болон аман илтгэл, үзүүлэн илтгэл (poster) тавих, илтгэлээ хураангуйд хэвлүүлэх;
- 3.2.3. улсын хэмжээний хуралд аман илтгэл болон үзүүлэн илтгэл тавих, илтгэлээ хураангуйд хэвлүүлэх;
- 3.2.4. сургуулийн хэмжээний хуралд илтгэл тавих;
- 3.2.5. монограф хэвлүүлэх, докторын болон шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл туурвих;
- 3.2.6. сурах бичиг, гарын авлага бичих, орчуулах;
- 3.2.7. зохиогчийн эрхээр баталгаажуулсан бүтээл гаргах.

Эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажил, оюуны өмчийн бүтээл (30%)

- 3.2.8. шинэ бүтээл, оновчтой санал гаргаж, эрхийн хамгаалалт хийлгэх, патент, стандарт, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, зохиогчийн эрх авах, үйлдвэрлэлд технологи нэвтрүүлэх;
- 3.2.9. ШУТС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл удирдах, гүйцэтгэх;
- 3.2.10. төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол дахь олон улсын байгууллагын гэрээт, захиалгат болон МУИС-аас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил удирдах, гүйцэтгэх;
- 3.2.11. гадаадын сургууль, байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- 3.2.12. эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгээр сургуульд мөнгөн болон материаллаг хөрөнгө оруулалт хийх.

Эрдэм шинжилгээний бусад ажил (30%)

- 3.2.13. эрдэм шинжилгээний их семинар, мэргэжлийн семинар удирдах, оролцох, илтгэл тавих;
- 3.2.14. мэргэжлийн түвшинд хянагддаггүй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- 3.2.15. дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр ажиллах;
- 3.2.16. мэргэжлийн сурах бичиг, монограф, орчуулгын бүтээл редакторлах;
- 3.2.17. стандарт /MNS/ боловсруулж, батлуулах;
- 3.2.18. гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлэгдэх өгүүлэлд шүүмж бичих;
- 3.2.19. оюутан, магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлыг удирдаж илтгэл бэлтгүүлэх (ажлуудын хувийг хавсаргана);
- 3.2.20. оюутныг дагуулан сургах, эрдэм шинжилгээний дугуйлан удирдах;
- 3.2.21. докторантын зөвлөхөөр ажиллах;
- 3.2.22. МУИС-ийн d-space мэдээллийн санд өөрийн эрдэм шинжилгээний бүтээлийг оруулах.

3.3. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ

Мэргэжлийн үйлчилгээ (50%)

- 3.3.1. эрдэм шинжилгээний бүтээлд бичгээр шүүмж өгөх;
- 3.3.2. эрдэм шинжилгээний хялбаршуулсан болон сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх;
- 3.3.3. эрдмийн зэрэг хамгаалуулах, судалгааны бүтээлийг шүүн хэлэлцэх эрдмийн болон экспертийн зөвлөлд ажиллах;
- 3.3.4. сургалтын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ, санал өгөх;
- 3.3.5. эрдэм шинжилгээний лаборатори, кабинет, тоног төхөөрөмж, мэдээллийн сан хариуцан ажиллах;

- 3.3.6. сургалтын алба, тэнхимийн эрхлэгч/профессорын багийн ахлагчийн даалгавраар багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх эсвэл багшийн хичээлд сууж, дагалдан суралцах;
- 3.3.7. сургуулийн захиргааны шийдвэрээр заавар, дүрэм, журам, бусад баримт бичиг боловсруулах, хяналт шалгалтанд оролцох, оюутны байгууллага, номын сангийн үйл ажиллагаанд туслах;
- 3.3.8. улсын болон сургууль, тэнхимийн хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, комисст ажиллах;
- 3.3.9. мэргэжлийн холбоод, комисс, зөвлөлд томилолтын болон сонгуульд албан тушаал гүйцэтгэх;
- 3.3.10. зөвлөх багшаар ажиллах, оюутны соёл, олон нийтийн ажил зохион байгуулах зэргээр суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажилд оролцох;
- 3.3.11. МУИС-ийн эрдэм шинжилгээний ажлын бүртгэлд тусгагдаагүй эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажилд оролцох;
- 3.3.12. олон улсын болон улсын хэмжээний хурал, уулзалт семинар зохион байгуулах;
- 3.3.13. МУИС-ийн болон сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүнээр ажиллах;
- 3.3.14. судлаачид бүтээлийг нь зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу зөвшөөрөл авч ашиглах;
- 3.3.15. төр, засгийн бодлого, шийдвэрийн төсөлд шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, байгууллага, аж ахуйн нэгжийн захиалгаар бодлогын баримт бичиг, илтгэл, төсөл боловсруулах;
- 3.3.16. аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зөвлөгөө өгөх;
- 3.3.17. төлбөрийн чадваргүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;
- 3.3.18. өөрийн мэргэжлийн салбарт гарсан шинжлэх ухааны шинэ нээлт, ололт амжилттай танилцаж, түүнийг зааж буй хичээлдээ ашиглах;
- 3.3.19. мэргэжлийн болон спорт, урлагийн хамтлаг удирдах, уралдаан тэмцээнд оролцуулах.

Нийгмийн үйлчилгээ (50%)

Сургуулийн хамтын удирдлагын үйл ажиллагаа, олон нийт, соёл, боловсролын үйл хэрэгт ямар үүрэгтэй, хэрхэн оролцсоноо зохих баримтаар тайлагнана.

- 3.3.20. олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр сурталчилгаа хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- 3.3.21. өдөр тутмын сонин, хэвлэлд өгүүлэл, нийтлэл хэвлүүлэх;
- 3.3.22. үндэсний зөвлөхөөр ажиллах, урилгаар лекц унших;
- 3.3.23. ажлын хэсэг, зөвлөл, комиссийн гишүүнээр ажиллах, хурал семинар зохион байгуулахад оролцох;
- 3.3.24. МУИС-ийн нийгэмд гүйцэтгэх үүргийн дагуу төрөл бүрийн сургалт явуулахад оролцох, зохион байгуулах;
- 3.3.25. нийгэм, ард иргэдийн дунд сургуулийн нэр хүндийг өргөхөд хувь нэмэр оруулахуйц бусад ажил гүйцэтгэх;
- 3.3.26. сургуульд тодорхой хэмжээний орлого оруулах ажил гүйцэтгэх;
- 3.3.27. байгууллага, иргэдэд боловсрол, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, эрдэм, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах;
- 3.3.28. ЕБС-ийн сурагчдын авьяасыг нээн илрүүлж, дэмжих;
- 3.3.29. МУИС-ийн олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлэх;
- 3.3.30. сургууль, шинжлэх ухааны болон бусад байгууллагад зөвлөхөөр болон удирдах зөвлөлд сонгогдон ажиллах;
- 3.3.31. МУИС-ийн хамт олны зөвлөлийн гишүүнээр ажиллаж, тодорхой ажил хариуцан гүйцэтгэх;
- 3.3.32. урлаг, уран сайхны зохиол, бүтээл туурвих, бүтээлийн үзэсгэлэн гаргах.

4. Багшийн ажлын нэгдсэн үнэлгээний арга

4.1. Багшийн ажлын үнэлгээг хичээлийн жилийн туршид тодорхой хуваарийн дагуу

- Өөрийн үнэлгээний тайлан;
- Оюутны үнэлгээ;
- Комиссын үнэлгээ;
- Мэргэжлийн удирдлагын үнэлгээ гэсэн хүрээгээр явуулна.

4.2. Багшийн гүйцэтгэх ажлын үндсэн төрөл, ажлыг үнэлэгчид, тэдний үнэлгээний дүнд эзлэх хувийг дараах хүснэгтэд харуулав.

Гүйцэтгэх ажлын төрөл	Оюутны үнэлгээ	Комиссын үнэлгээ	Удирдлагын үнэлгээ
a. Сургалт, заах арга зүй	40%	30%	30%
b. Эрдэм шинжилгээ	-	55%	45%
c. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ	-	40%	60%

4.3. Үнэлгээг дараах аргачлалын дагуу явуулна.

4.3.1. Багш нь хийж гүйцэтгэсэн ажлаа үнэн зөв үнэлүүлэх үүднээс дэлгэрэнгүй тайлан бичиж, нотлох баримтуудыг хавсаргана. Багшийн ажлыг комисс, мэргэжлийн удирдлага үнэлэхдээ тайлан, хавсаргасан материалд голлон үндэслэнэ.

4.3.2. Оюутны үнэлгээг сүүлийн 3 жилийн санал асуулгын дунджаар гаргана. Оюутны санал асуулгыг төв сургалтын албанаас боловсруулсан үлгэрчилсэн асуулгын хуудсаар авах бөгөөд асуулгын эх материалыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба хадгалж, үр дүнгийн хамт тухайн багшид шалгалтын дүн гарсны дараа өгнө.

4.3.3. Аттестатчилалд орж буй багшийн тооноос хамааран бүрэлдэхүүн сургуулийн комисс 3-5 хүнтэй байх ба өөр сургуулийн туршлагатай багшийг комисст ажиллуулж болно. Тухайн хичээлийн жилд өөр өөр мэргэжлийн олон багшийн ажилд үнэлгээ өгөх шаардлага гарвал комиссын гишүүдэд туслах үүрэгтэйгээр тухайн мэргэжлийн хүмүүсийг захирлын тушаалаар томилон ажиллуулж болно.

4.3.4. Багш тэнхим/профессорын багийн хамт олны өмнө ажлын тайлангаа тавьж, нээлттэй хичээл хийнэ. Багшийн ажилд хамт олны өгсөн үнэлгээг протоколоор үйлдэн тайлангийн материалд хавсаргана.

4.4. Биеийн тамир, мэргэжлийн бус ангийн гадаад хэлний хичээл заадаг багш нарын эрдэм шинжилгээний ажлын үнэлгээг харьяалах нэгжийн саналыг үндэслэн энэ журамд зааснаас өөрөөр хийж болно.

5. Нэгдсэн үнэлгээний тооцоо хийх²

5.1. Тооцоог гаргахдаа үнэлэгчээс өгсөн оноог 4.2. дах заалтанд буй хүснэгтэнд заасан хувиар харгалзуулан үржүүлж хооронд нь нэмнэ. Тухайлбал, ахлах багшийн сургалт, заах арга зүйн ажлын үнэлгээнд үнэлэгч бүрийн өгч болох дээд оноо 40 байх бөгөөд оюутны үнэлгээ 35, комисс 30, мэргэжлийн удирдлага 36 оноогоор тус тус дүгнэсэн гэвэл багш сургалтын ажлаар авбал зохих 40 онооноос $a = 35 \times 0.4 + 30 \times 0.3 + 36 \times 0.3 = 33.8$ оноо авлаа гэсэн үг юм.

a. Сургалт, заах арга зүй: дээд оноо _____

1. Оюутны үнэлгээ, a_1 (40%) _____

2. Комиссын үнэлгээ, a_2 (30%) _____

3. Удирдлагын үнэлгээ a_3 (30%) _____

Авах оноо: $a = a_1 \times 0.4 + (a_2 + a_3) \times 0.3 =$ _____

b. Эрдэм шинжилгээ: дээд оноо _____

1. Комиссын үнэлгээ, b_2 (55%) _____

2. Удирдлагын үнэлгээ, b_3 (45%) _____

² Үнэлгээг нэгдсэн аргачлалаар хийх программыг SISI системд байрлуулж, комисс шууд ашиглах боломжийг хангана.

Авах оноо: $b = b_2 \times 0.55 + b_3 \times 0.45 = \underline{\hspace{2cm}}$

с. Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ: дээд оноо $\underline{\hspace{2cm}}$

1. Комиссын үнэлгээ, c_2 (40%) $\underline{\hspace{2cm}}$

2. Удирдлагын үнэлгээ, c_3 (60%) $\underline{\hspace{2cm}}$

Авсан оноо: $c = c_2 \times 0.4 + c_3 \times 0.6 = \underline{\hspace{2cm}}$

Нэгдсэн үнэлгээний дүн: $a + b + c = \underline{\hspace{2cm}}$

6. Багшийн ажлын үнэлгээний үйл ажиллагаа

6.1. Багшийн ажлыг жилийн турш үнэлэх үйл ажиллагааг дараах шат дарааллаар явуулна.

Үүнд:

6.1.1. Багш хичээлийн жилийн эхнээс үнэлгээний чиглэл бүрээр хийх гол ажлын агуулгыг багтаасан төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.1.2. Багш гүйцэтгэсэн ажлынхаа тайланг загварын дагуу бичиж, зохих хавсралтуудын хамт тэнхимийн эрхлэгч/профессорын багийн ахлагчид өгнө. Тэд багшийнхаа тайланг нарийвчлан судалж, тодорхойлолт (нэг хуудас орчим) гаргана.

6.1.3. Оюутны үнэлгээг улирал бүрийн эцэст шалгалт эхлэхээс өмнө бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас зохион байгуулан авч, дүнг нэгтгэн улирлын шалгалтын дүн гарснаас хойш тэнхим/профессорын багт хүргүүлнэ. Оюутны үнэлгээний эх хувийг харьцуулсан судалгааны материал болгон ашиглах ба нэг жил хадгална.

6.1.4. Багшийн эрдэм шинжилгээний ажлыг үнэлэхдээ өмнөх аттестатчиллаас хойших хугацаагаар авч үзнэ.

6.1.5. Мэргэжлийн удирдлагын үнэлгээг захирал, тэнхимийн эрхлэгч/профессорын багийн ахлагч, сургалтын албаны эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар хамтарч хийнэ.

6.1.6. Комисс багшийн үндсэн үйл ажиллагааны чиглэл бүрт өөрсдийн үнэлгээ өгч, улмаар оюутны болон удирдлагын үнэлгээтэй нэгтгэн багшийн нэгдсэн үнэлгээг гаргана. Ажлын гүйцэтгэлд комиссын зүгээс үнэлгээ өгөхдөө багшийн өөрийн үнэлгээний тайлан, мэргэжлийн онцлог, ажлын чанарыг голлон анхаарна.

6.1.7. Бүрэлдэхүүн сургуулийн захирал аттестатчиллыг хэрхэн зохион байгуулсан, үр дүнгээр нь тухайн багшийн албан тушаалын зэрэглэлийг ахиулах/бууруулах, цалингийн шатлалыг өөрчлөн тогтоох, хөдөлмөрийн гэрээг сунгах/цуцлах, багш нарын үйл ажиллагааны ололттой болон анхаарвал зохих асуудлын талаар комиссын тайлан бичиж, сургуулийнхаа эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, багш бүрийн талаар дүгнэлт гаргуулна.

6.1.8. Комиссын тайлан, бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн дүгнэлт, багш нарын нэгдсэн үнэлгээний жагсаалтыг ЗХШҮА нэгтгэн МУИС-ийн Захиргааны зөвлөлд танилцуулж, зохих шийдвэр гаргуулна.

6.2. Аттестатчиллын явцад ЗХШҮА хяналт тавьж ажиллана.

7. Нэгдсэн үнэлгээний үр дүнг тооцох

Аттестатчилал нь тодорхой хугацаанд багшийн хийж гүйцэтгэсэн ажлын бүтээл, үр дүнг үнэн бодитой үнэлэх замаар түүний үйл ажиллагааны ололт, дутагдал, цаашид удирдлага болон багшийн зүгээс анхаарах асуудлуудыг илрүүлэн гаргах чухал арга хэрэгсэл болохын хувьд энэ ажлын үр дүн нь багшийг дэмжиж урамшуулах эсвэл хариуцлага тооцох үндсэн шалгуур юм.

7.1. **А** (90-100): Ийм үнэлгээ авсан багшийн ажлын үр дүнг хангалттай сайн гэж үзнэ. Уг багшид зохих урамшуулал олгож болох ба асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл шийдвэрлэнэ.

7.2. **В** (70-89): Эрхэлсэн ажилдаа тэнцэж байна гэж үзнэ.

7.3. **С** (70-79): Ажилдаа тэнцэж байна гэж үзэх боловч тухайн багшид бага оноо авсан ажлын үзүүлэлтээ сайжруулах хугацаатай даалгавар өгнө.

